115

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2013 оны 05 сарын 01 өдөр Дугаар А/266 Булган

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгагдсан Булган аймгийн Бүрэгхангай, Хишиг-Өндөр, Могод, Сэлэнгэ сумын 300 га талбайд хийгдэх ойжуулалтын ажлын тендерийн 1-р багцын гүйцэтгэгчээр шалгарсан "БУЦС" нөхөрлөлтэй 66 000 000 /жаран зургаан сая/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар /А.Гантөмөр/-т олгосугай.
2. Гүйцэтгэгч "БУЦС" нөхөрлөлтэй холбогдох хууль, тогтоомжийн дагуу гэрээг байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, хүлээн авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар /А.Гантөмөр/-т даалгасугай.
3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "БУЦС" нөхөрлөл /З.Баасансүрэн/-д үүрэг болгосугай.
4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний сангаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /С.Цэдэнлхам/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА З.БАТЗОРИГ